

**Оросын нэрт монгол судлаач эрдэмтэн, МУИС-ийн нийгэм, хүмүүнлэгийн  
Хүндэт доктор болов**

Доктор (Sc.D), профессор Ц.Жамбалсүрэн

ОХУ-ын Эрхүү хотын УИС, Байгалийн эдийн засаг, эрхийн их сургуулийн профессор Юрий Васильевич Кузьмин нь Оросын монгол судлалын томоохон төлөөлөгч, орчин үеийн Монголын нийгмийн сэтгэлгээний судалгааны салбарын нэртэй мэргэжилтэн юм.

Юрий Васильевич Кузьмин нь 1954 онд Буриад улсын Корсаково Кабаны районод төржээ. Түүний эцэг нь нефть-газын олон орд газрыг нээсэн ОХУ-ын Гавьяат геологич ажээ.

1971 онд Якутын Кызыл-Сыр тосгоны дунд сургууль төгсөж, 1972-1974 онд цэргийн алба хааж, 1975-1980 онд Эрхүүгийн УИС-ын Түүхийн факультетэд суралцаж төгсжээ. Нэгдүгээр дамжаанд байхдаа Монголын түүхээр мэргэжихээр санаа шулуудаж, 1976 оны зун Монгол улсад түүх, археологийн дадлага хийж, 1977, 1978 онд түүхийн танилцах дадлага тус тус хийж, Монголын түүхийн ном сурвалж цуглуулж, Монгол, Оросын томоохон түүхчидтэй танилцаж, судалгааны гараагаа эхэлжээ.

1980-1986 онд Ленинградын УИС-ийн Дорно дахины факультетэд мэргэжил дээшлүүлэн улмаар аспирантурт суралцаж, 1986 онд “Монголын капиталист бус хөгжлийн замын үндсэн асуудлын тухай орчин үеийн Монгол дахь нийгмийн сэтгэлгээ” сэдвээр түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалж, 1998 онд Эрхүүгийн УИС-д “Оросын нийгэм улс төрийн сэтгэлгээн дэх “Монгол, Урианхайн асуудал”” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Профессор Юрий Васильевич Кузьмин 1985-2000 он хүртэл Эрхүүгийн УИС-ын Монгол оюутны бэлтгэл факультетэд доцентоор ажиллаж, оюутнуудад Монголын ба Оросын түүхийн хичээл зааж, манай оюутнуудын хүндтэй дотны багш сурган хүмүүжүүлэгч нь болсон юм. Тэрээр “Нийгэм улс төрийн орос, монгол толь”, “Современная Монголия”, “МНР в современном мире” гарын авлага, товхимол бичсэн нь олон жил сургалт хүмүүжлийн ажилд хэрэглэгдсэн юм.

Оюутны хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцож, Монголыг сурталчилсан үзэсгэлэн хэд хэдэн удаа зохион байгуулсан нь үр дүнтэй болжээ. Эрхүүгийн УИС-ын түүхийн салбарт Монголын түүхийн тусгай курс зохион байгуулж, бэлтгэл ангид Монголын түүхийн хичээлийг албан ёсоор заах асуудлыг шийдэхэд тэрээр чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

1999 онд Эрхүүгийн УИС-ийн дэргэд Монгол судлалын эрдэм шинжилгээ, мэдээллийн төвийг үүсгэн байгуулалцаж, төвийн орлогч захирлаар ажиллаж, энэ хотын түүхч эрдэмтэд, оюутан залуусын дунд монгол судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан байна. Түүний удирдлагаар арав гаруй оюутан Монголын асуудлаар дипломын ажил амжилттай хамгаалжээ.

Юрий Васильевич Кузьмин 2000 оноос Байгалийн эдийн засаг эрх, зүйн их сургуулийн Дэлхийн эдийн засгийн тэнхимд шилжин ажиллах болсноор Монголд зориулан мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх том уурхай болсон энэ сургуульд Дорно дахины судлал, түүний дотор Монгол судлал эрчимтэй хөгжих болов.

2001 онд проф. Юрий Васильевич Кузьмины удирдлагаар Байгалийн их сургуулийн дэргэд Дорно дахины соёлын шинжлэх ухаан, мэдээллийн төв байгуулагдаж, 1911, 1921 оны Монголын хувьсгалд зориулсан Дугуй ширээний уулзалт, ярилцлага хийсэн нь судалгаа, танин мэдэхүйн ихээхэн ач холбогдолтой болжээ. Тус төв жил тутам “Дорно дахины уншлага”-эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байна.

Профессор Юрий Васильевич Кузьмин Оросын түүх, Монголын түүх, Дэлхийн эдийн засгийн түүх, Сибирийн түүх, Дорнод Азийн орнуудын эдийн засгийн түүх, Дорно

дахин орнуудын соёл, Гадаад орон судлал зэрэг хичээлийг их сургуульд олон арван жил заасан Дорно дахин судлалын томоохон мэргэжилтэн юм. Түүнчлэн орос оюутанд олон жил монгол хэл заажээ.

Оросын ШУА-ийн Монгол судлалын нийгэмлэг, түүний Эрхүүгийн салбарын гол зохицуулагч, зохион байгуулагч болохын хувьд Юрий Васильевич Кузьмин Олон улсын Монгол судлалын холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож иржээ.

Олон улсын Азийн судалгааны төвийн удирдагч, энэ төвийн Вестник, “Дорнод судлалын уншлага” жил тутмын сэтгүүлийн ерөнхий эрхлэгчээр ажиллахын хамт 2008 онд Байгалийн УИС-ын дэргэд Монголын судлалын төв шинээр байгуулсан нь энэ салбарын судалгааны хөгжилд проф. Юрий Васильевич Кузьмин томоохон үүрэг гүйцэтгэдэг эрдэмтэн болохыг харуулж байна.

Проф. Юрий Васильевич Кузьмин нь Монгол судлалаар 11 нэгэн сэдэвт бүтээл (монографи) туурвиж, 250 эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, Орос, Монгол, АНУ, Францад нийтлүүлжээ.

МУИС-ийн НШУС-ийн Эрдмийн зөвлөл энэ оны V сард Монгол, Оросын найрамдал нөхөрлөл, их сургуулиудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, олон улсын монгол судлалыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсан Оросын нэрт монгол судлаач Юрий Васильевич Кузьминд МУИС-ийн нийгэм-хүмүүнлэгийн Хүндэт доктор цол олгох шийдвэр гаргажээ.

Нэрт монгол судлаач Ю.В.Кузьминд МУИС-ийн хамт олон, түүний дотор бүх түүхчид халуун баяр хүргэж байна.